



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
ЛУВСАННАМСРАЙН ОЮУН-ЭРДЭНЭ
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2022. 04.18 № 19

Асуулга тавих тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Танд дараах асуулгыг тавьж байна.

1. Оросын Холбооны Улс (ОХУ)-аас Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ)-руу байгалийн хийн хоолой барьж байгуулах төслийн үйл явц, үр дүн, эрсдэл зэрэг нь Украин Улсад ОХУ-ын зүгээс халдан түрэмгийлсэн дайны үйл явцтай холбогдон манай нийгэмд олон нийтийн анхаарлыг татсан хэлэлцүүлгийн сэдэв болоод байна. Энэ эгзэгтэй үед Монгол Улсын Их Хурал энэ асуудлаарх Монгол Улсын Засгийн газрын бодлого, чиглэл, үйл ажиллагааны талаарх бодит мэдээллийг авах шаардлагатай гэж үзлээ.

Хэвлэл, мэдээллийн хэрэгслэлээр гарсан мэдээллээс үзэхэд 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдөр ОХУ-ын "Газпром" компани ба Монгол Улсын Засгийн газар хооронд Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байгалийн хийн хоолой барьж байгуулах боломжийг судлах санамж бичигт гарын үсэг зурсан бөгөөд түүнээс хойш ганцхан жилийн дотор төслийн урьдчилсан Техник, эдийн засгийн үндэслэлийг (ТЭЗҮ) болон үндсэн ТЭЗҮ-ийг боловсруулж бэлэн болгожээ. Улмаар 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр уг төслийн ТЭЗҮ-ийг эцэслэн баталсан тухай протоколд Монгол Улсын Засгийн газар болон "Газпром" компани гарын үсэг зурсан байна. Энэ өдрөөс ердөө 1 сарын дараа буюу 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдөр Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, ОХУ-ын "Газпром" НХН-ийн Удирдах зөвлөлийн дарга А.Б.Миллер нар төслийн Зураг төсөл, инженерийн хайгуул судалгааны ажлуудыг эхлүүлэх тухай гэрээнд гарын үсэг зуржээ. Төслийн хүрээнд ОХУ-аас Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан БНХАУ-руу 962.9 км урттай байгалийн хийн хоолой барьж байгуулан, жилд 50 тэрбум шоо метр байгалийн хий тээвэрлэх зорилготой гэсэн мэдээлэл байна.

Монгол Улсын эдийн засгийн болон геоулстөрийн нөхцөл байдалд асар их нөлөө үзүүлэх боломжтой энэхүү төслийн ажил гэнэт хурдацтай өрнөх болсон нь зарим иргэд, сонгогчдод төдийгүй надад ч мөн эргэлзээ, болгоомжлол төрүүлж байна.

Иймд:

- Төсөл хэрэгжсэнээр Монгол Улсын Үндэсний аюулгүй байдалд Украин Улсад учирсантай адилтгах геоулстөрийн шалтгаантай аливаа эрсдэл учирч


2022000033

- болзошгүй талаарх судалгаа, мэдээлэл, дүгнэлт байгаа эсэх талаар болон, байгаа бол холбогдох мэдээлэл;
- Хийн хоолойн бүтээн байгуулалтын зардал хаанаас гарах, цаашид хэний өмчлөл, эзэмшилд үлдэх, дамжуулалтын төлбөр, өртөг хэрхэн тооцогдох, Монгол Улсад өгөх өгөөж, Монгол Улс дамжуулж буй байгалийн хийн хэрэглэгч болох эсэх, хэрэглэх тохиолдолд хэн, ямар хэмжээгээр хэрэглэх эсэх талаар;
 - Дээр дурдсан гэрээний дагуу байгалийн хий дамжуулах хоолойн барилга байгууламжийг барихад зориулан газар олгох асуудлыг Монгол Улсын Засгийн газар энэ оны 12 дугаар сард багтаан шийдэх үүрэг хүлээсэн бололтой. Гэтэл хамгаалалтын зурвасыг хийн хоолойн голчоос 50 метр хүртэл өргөнтэй байдаг дэлхийн жишгээс хэт өргөнөөр буюу 1 километр өргөнтэй байхаар тохиролцсон гэсэн мэдээлэл олон нийтийн дунд тархаад байна. Энэ талаарх бодит мэдээллийн талаар;
 - ОХУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд И.К.Азизов саяхан „Парламент“ телевизэд өгсөн ярилцлагынхаа үеэр “Хийн хоолойн харуул хамгаалалтын асуудал босох хүртэл хол байна. Тэгэхдээ хэзээ нэгэн цагт энэ асуудал босож ирвэл монголын нутаг дэвсгэр дээр байрлах энэхүү объектыг хэн хамгаалах вэ гэдэг асуудлыг тэр цагт нь л ярьна” хэмээн мэдэгдсэн нь нэг бол Монгол Улсын Засгийн газрын зүгээс Монгол Улсын Үндсэн хуулийн Дөрөвдүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Арван нэгдүгээр зүйл, Хорьдугаар зүйлийг зөрчсөн агуулгатай гэрээ, хэлэлцээрийг айлийн талтай хийсэн, эсвэл Элчин сайд И.К.Азизов Монгол Улсын Үндсэн хуулийн энд дурдагдсан заалтуудыг үл ойшоосон хандлага үзүүлсэн гэх хоёр нөхцөл байдлын аль нэгийг илэрхийлж байна гэж үзэж байна. Тиймээс энэ асуудалд холбогдох аливаа гэрээ, хэлэлцээр, хэлцлийн талаарх бодит мэдээлэл;

2. ОХУ-ын сенатч Константин Косачев хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр “АНУ-ын зүгээс Украинд байсан биологийн нууц лабораторийг Монгол Улсад нүүлгэн шилжүүлэхээр төлөвлөж байна” гэсэн агуулгатай мэдээллийг тараасантай холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын зүгээс уг худал мэдээллийг няцаах талаар дипломат шугамаар ямар арга хэмжээ авсан болон авахаар төлөвлөж байгаа талаарх мэдээллийг тус тус гаргаж ирүүлнэ үү.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т заасан хугацаанд бичгээр ирүүлэх бөгөөд мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу шаардлагатай гэж үзвэл Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх болно.

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Т.ДОРЖХАНД

2022060033